

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/38/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь аймаг Сайншанд сум 2018 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 99092469 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Лүндэгмаа Утас: 99026829 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn Аудитор: Б.Уранбилэг Утас: 99064332 Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

## АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал .....	12
3.1	санхүүгийн тайлангийн аудит .....	12
3.1.1	Илрүүлэлт .....	12
3.1.2	Эрсдэл.....	12
3.1.3	Өгсөн зөвлөмж.....	12
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: .....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19

## 1 Аудитын гэрчилгээ

 <b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, Орон дутгайга олонийн III байр, Утас: (705) 2-27-34	<b>ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬААТЫН ГАЗРЫН ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ГАЗРЫН ДАРГА П.ТУЛГА ТАНАА</b>
2019.01.29 № 1-6/37	
Танай _____ -ны № _____ -т	
<b>Аудитын гэрчилгээ</b>	
<p>Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газар - ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар.- аас аудит хийв.</p>	
<p>Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.</p>	
<p>Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.</p>	
<b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газар - ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулга материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.</p>	
<b>4451844</b>	

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газар - ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга П.Тулгад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 22-оос 2019 оны 1 дүгээр сарын 24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Уранбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 19 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын нь “Байгууллагын эрхэм зорилго нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний эрх ашгийг дээдэлж, олон улсын жишигт нийцсэн нээлттэй, хариуцлагатай үйл ажиллагааг явуулахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратегиар Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Удирдлагын шилдэг арга барил, туршлагыг нэвтрүүлэх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар удирдлагын манлайллыг хангах, иргэн, аж ахуй нэгж, байгууллагад үзүүлэх үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэх.
- Хүний нөөцийн удирдлагын шилдэг арга барилыг хэрэглэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар оновчтой цомхон, чадварлаг бүтцийг бий болгох, хөгжүүлэх.

- Олон улсын болон гадаад орны ижил төстэй байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, иргэд харилцан зорчих нөхцлийн талаарх олон улсын болон хоёр талт гэрээний хэрэгжилтийг хангах.
- Нээлттэй, ил тод, шуурхай, чанартай, хүртээмжтэй ажил, үйлчилгээ үзүүлэх, Гадаадын иргэн харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсах.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Монгол Улсын хилийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Харьяатын тухай хууль
- Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль
- Ажиллах гадаадаас гаргах, гадаадад ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль
- Аялал жуулчлалын тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журам

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын ДГА-2019/38/СТА-ТШЗ

шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Гадаадын иргэн, харьяатын Дорноговь аймаг дахь газрын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл Бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програм хангамж ашигладаг байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 1 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлын материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь үйл ажиллагаатай холбоотой юм.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2018 оны нийт зардал хагас жилээр 386484.3 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 3864.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь дунджаар тооцсонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад залруулах боломжтой гэж үзлээ. Энэ үр дүнг В30101 маягтаар баталгаажуулав. Харин аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар тус тус нэгтгэн баталгаажуулав.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа,  
зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	1267.2	Холбогдох журмыг баримталж ажиллах, илэрсэн зөрлийг арилгах.
2	Албан шаардлага өгсөн	1	142.6	Дутуу тооцсон цалин нөхөж олгох
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>1409.8</b>	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Цалингийн зардлаас 463.8 мянган төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27 -ны өдрийн 388 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар"-ыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Үр дүнг зөвшөөрч аудитын явцад шууд зардалд бичилтийг алдааг залруулав.

2.8.1.2 Тус байгууллагын хяналтын улсын байцаагч Д.Нямдоржийн 2017 онд олгох цалинг буруу тооцож олгосны улмаас 2018 оны 1 дүгээр сард дээрх цалингийн зөрүү олгосон байна. Энэ зөрүүг тооцохдоо НДШ болон ХХОАТ 2 удаа суутгаж нийт 142.5 мянган төгрөг дутуу олгосон байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Хувь хүний орлогын албан татварын хуулийн 23 дугаар зүйлд заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх тооцсон цалингийн зөрүүг Д.Нямдоржид нөхөн олгох тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.8.1.3 Тус байгууллагын ажиллагсад 2018 онд ээлжийн амралтын олговрыг олгохдоо холбогдох аргачлалын дагуу тооцоогүйгээс 8 ажилтанд 139.5 мянган төгрөг илүү, 14 ажилтанд нийт 1127.8 мянган төгрөгийг дутуу олгосон байна. Энэ нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан "Ээлжийн амралтын олговор тооцох журам"-д заасан аргачлалыг мөрдөж ажиллаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх зөрчилд Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан "Ээлжийн амралтын олговор тооцох журам"-ыг мөрдөж ажиллах, илүү, дутуу тооцсон олговрыг залруулж ажиллах тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

## 2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

## 2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 8 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 427587.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 414391.1 мянган төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь зарим зардалд 13196.6 мянган төгрөгийн хэмнэлттэй үүссэнээс шалтгаалжээ.

## 2.11 Шилэн дансны мэдээлэл

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

##### **3.1.1 Илрүүлэлт**

Ээлжийн амралтын олговрыг буруу тооцсон. Энэ нь “Үнэлгээ”, “Хэмжилт”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна. Энэ зөрчил нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан “Ээлжийн амралтын олговор тооцох журам”-ыг мөрдөж ажиллаагүй байна.

##### **3.1.2 Эрсдэл**

Ээлжийн амралтын олговрыг аргачлалын дагуу тооцоогүйгээс ажилчдад илүү, дутуу олгох.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж**

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан “Ээлжийн амралтын олговор тооцох журам”-ыг мөрдөж ажиллах, илүү, дутуу тооцож олгосон олговрыг залруулах.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019/03/01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	35,128,002.50	68,610,126.52
35	БАРАА МАТЕРИАЛ	35,128,002.50	68,610,126.52
35400	Хангамжийн материал	35,128,002.50	68,610,126.52
35410	Бичиг хэргийн материал	3,979,654.00	6,141,804.00
35420	Аж ахуйн материал	11,132,366.50	28,216,088.45
35430	Сэлбэг хэрэгсэл	213,300.00	213,300.00
35440	Түлш,шатах тослох материал	380,000.00	634,000.00
35450	Барилгын засварын материал	2,612,690.00	1,415,700.00
35470	Бусад хангамжийн материал	16,809,992.00	31,989,234.07
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	740,680,771.76	860,028,341.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	740,680,771.76	860,028,341.38
39200	Биет хөрөнгө	740,680,771.76	851,650,841.38
39201	Барилга,байгууламж,орон сууц	707,153,416.10	781,245,814.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	65,823,058.74	0.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,000,000.00	20,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	6,666,666.72	10,000,000.08
39205	Машин,тоног төхөөрөмж (компьютер)	150,711,684.62	123,913,831.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	87,826,674.04	81,080,495.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,527,657.33	46,544,451.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	31,395,586.79	28,972,760.92
39300	Биет бус хөрөнгө	0.00	8,377,500.00
39301	Програм хангамж	0.00	1,980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	82,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	6,480,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	775,808,774.26	928,638,467.90
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН	775,808,774.26	928,638,467.90
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	6,821,741.82
51100	Засгийн газрын оруулсан капитал	0.00	6,821,741.82
51200	Хуримтлагдсан үр дүн	775,808,774.26	770,457,120.58
51210	Өмнөх үеийн үр дүн	775,808,774.26	775,808,774.26
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-5,351,653.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	151,359,605.50
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	775,808,774.26	928,638,467.90

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
I	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	510,980,235.75	467,587,835.05
12	<u>ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,127,935.75	40,000,135.05
120	<u>Нийтлэг татварын бус орлого	82,110,235.75	40,000,135.05
120004	<u>Төсөв байгууллагын өөрийн орлого	82,110,235.75	40,000,135.05
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	82,110,235.75	40,000,135.05
122	<u>Тусламжийн орлого	3,017,700.00	0.00
122001	Хандив тусламж /дотоод	3,017,700.00	0.00
13	<u>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	425,852,300.00	427,587,700.00
1310	<u>Улсын төвлөрсөн төсвөөс	425,852,300.00	427,587,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	425,852,300.00	427,587,700.00
II	<u>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	539,014,813.72	472,939,488.73
21	<u>УРСГАЛ ЗАРДАЛ	497,418,511.70	472,939,488.73
210	<u>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	497,418,511.70	456,743,295.89
2101	<u>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	281,744,475.08	279,062,520.86
210101	Үндсэн цалин	189,580,975.00	174,272,236.07
210102	Нэмэгдэл	58,349,700.08	74,151,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,813,800.00	30,638,984.79
2102	<u>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,679,685.31	33,665,304.12
210201	Тэтгэврийн даатгал	21,988,108.49	21,921,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,909,304.00	3,140,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,075,277.00	1,893,248.67
210204	Ажилгүйдлийн даатгал	518,823.00	628,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,188,172.82	6,082,955.45
2103	<u>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,142,525.88	35,159,626.20
210301	Гэрэл, цахилгаан	5,780,236.00	8,475,817.90
210302	Түлш, халаалт	22,733,289.66	19,554,808.30
210303	Цэвэр, бохир ус	7,629,000.22	7,129,000.00
2104	<u>Хангамж, бараа материалын зардал	22,306,583.50	41,337,103.64
210401	Бичиг хэрэг	2,750,227.00	3,911,350.00
210402	Тээвэр, шатахуун	11,881,900.00	22,234,700.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,218,413.70	3,310,205.98
210404	Ном, хэвлэл	0.00	155,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,456,042.80	3,507,530.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	8,218,317.66
2105	<u>Нормативт зардал	31,126,102.00	3,320,663.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,126,102.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	3,320,663.60

(Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	<u>Эд хогшил, урсгал засварын зардал	12,131,332.40	8,803,700.00
210604	Урсгал засвар	12,131,332.40	8,803,700.00
2107	<u>Томилолт, зочны зардал	1,539,750.00	3,812,500.00
210702	Дотоод албан томилолт	1,539,750.00	3,812,500.00
2108	<u>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,838,348.00	4,703,136.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	469,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	237,050.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	804,875.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,033,473.00	3,941,186.00
2109	<u>Бараа үйлчилгээний бусад зардал	78,909,709.53	46,878,741.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,349,060.00	2,660,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	595,900.00	1,469,920.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	75,964,749.53	42,748,521.47
213	<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,596,302.02	16,196,192.84
2132	<u>Бусад урсгал шилжүүлэг	5,436,000.00	2,999,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,536,000.00	2,999,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,900,000.00	0.00
2133	<u>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	13,196,592.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	13,196,592.84
2135	<u>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,160,302.02	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,160,302.02	0.00
III	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-28,034,577.97	-5,351,653.68
V	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	309,554,956.33	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	305,865,330.33	0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,689,626.00	0.00
VI	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-309,554,956.33	-5,351,653.68
VII	НИЙТ ҮР ДҮН	-337,589,534.30	0.00

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
0	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө	0.00	0.00
I	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	425,852,300.00	427,587,700.00
13	<u>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	425,852,300.00	427,587,700.00
1310	<u>Улсын төвлөрсөн төсвөөс	425,852,300.00	427,587,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	425,852,300.00	427,587,700.00
II	<u>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	425,852,300.00	427,587,700.00
21	<u>УРСГАЛ ЗАРДАЛ	425,852,300.00	427,587,700.00
210	<u>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	384,255,997.98	411,391,507.16
2101	<u>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	281,762,300.08	279,062,520.86
210101	Үндсэн цалин	189,598,800.00	174,272,236.07
210102	Нэмэгдэл	58,349,700.00	74,151,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,813,800.00	30,638,984.79
2102	<u>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,923,066.32	33,665,304.12
210201	Тэтгэврийн даатгал	20,546,713.32	21,921,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,594,080.00	3,140,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,075,277.00	1,893,248.67
210204	Ажилгүйдлийн даатгал	518,823.00	628,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,188,173.00	6,082,955.45
2103	<u>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,862,232.88	35,159,626.20
210301	Гэрэл, цахилгаан	5,780,236.00	8,475,817.90
210302	Түлш, халаалт	22,452,996.66	19,554,808.30
210303	Цэвэр, бохир ус	7,629,000.22	7,129,000.00
2104	<u>Хангамж, бараа материалын зардал	19,564,863.70	32,183,105.98
210401	Бичиг хэрэг	3,273,400.00	4,700,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,001,900.00	19,488,700.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,218,413.70	3,295,205.98
210404	Ном, хэвлэл	0.00	210,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,071,150.00	4,489,200.00
2106	<u>Эд хогшил, урсгал засварын зардал	3,287,800.00	10,416,500.00
210604	Урсгал засвар	3,287,800.00	10,416,500.00
2107	<u>Томилолт, зочны зардал	1,539,750.00	3,812,500.00
210702	Дотоод албан томилолт	1,539,750.00	3,812,500.00
2108	<u>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,672,875.00	6,061,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	3,469,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	237,050.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,484,875.00	2,000,000.00

(Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,188,000.00	300,000.00
2109	<u>Бараа үйлчилгээний бусад зардал	8,643,110.00	11,030,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,046,310.00	8,320,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,596,800.00	2,710,000.00
213	<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,596,302.02	16,196,192.84
2132	<u>Бусад урсгал шилжүүлэг	5,436,000.00	2,999,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,536,000.00	2,999,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,900,000.00	0.00
2133	<u>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,160,302.02	13,196,592.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	13,196,592.84
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,160,302.02	0.00
VIII	<u>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
IX	<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
X	<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

#### 4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оын 01 сарын 01-ээр үлдэгдэл	0.00	0.00	1,113,398,308.56	1,113,398,308.56
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	-337,589,534.30	-337,589,534.30
2017 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	0.00	0.00	775,808,774.26	775,808,774.26
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,821,741.82	0.00	0.00	6,821,741.82
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	151,359,605.50	0.00	151,359,605.50
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	-5,351,653.68	-5,351,653.68
2018 оын 12 сарын 31-р үлдэгдэл	6,821,741.82	151,359,605.50	770,457,120.58	928,638,467.90

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	427,587,700.00	414,391,107.16	13,196,592.84	96.91
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	427,587,700.00	414,391,107.16	13,196,592.84	96.91
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	424,587,700.00	411,391,507.16	13,196,192.84	96.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	102,593,100.00	98,663,682.18	3,929,417.82	96.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	287,513,100.00	279,062,520.86	8,450,579.14	97.06
210101	Үндсэн цалин	176,401,800.00	174,272,236.07	2,129,563.93	98.79
210102	Нэмэгдэл цалин	74,151,300.00	74,151,300.00	0.00	100.00
210103	Унаа хоолны нэмэгдэл	36,960,000.00	30,638,984.79	6,321,015.21	82.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,481,500.00	33,665,304.12	816,195.88	97.63
210201	Тэтгэврийн даатгал	21,921,000.00	21,921,000.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,140,100.00	3,140,100.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,512,100.00	1,893,248.67	618,851.33	75.37
210204	Ажилгүйдлийн даатгал	628,000.00	628,000.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,280,300.00	6,082,955.45	197,344.55	96.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,777,300.00	35,159,626.20	3,617,673.80	90.67
210301	Гэрэл, цахилгаан	10,686,100.00	8,475,817.90	2,210,282.10	79.32
210302	Түлш, халаалт	20,961,400.00	19,554,808.30	1,406,591.70	93.29
210303	Цэвэр, бохир ус	7,129,000.00	7,129,000.00	0.00	100.00
210304	Байрны түрээс	800.00	0.00	800.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,494,800.00	32,183,105.98	311,694.02	99.04
210401	Бичиг хэрэг	4,700,000.00	4,700,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	19,488,700.00	19,488,700.00	0.00	100.00
210403	Шуудан,холбоо, интернетийн төлбөр	3,606,900.00	3,295,205.98	311,694.02	91.36
210404	Ном, хэвлэл	210,000.00	210,000.00	0.00	100.00
210406	БҮТЭЗүйлс	4,489,200.00	4,489,200.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,416,500.00	10,416,500.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	10,416,500.00	10,416,500.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	3,812,500.00	3,812,500.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	3,812,500.00	3,812,500.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,062,000.00	6,061,950.00	50.00	100.00
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,469,900.00	3,469,900.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,100.00	237,050.00	50.00	99.98
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх,бэлтгэх	300,000.00	300,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,030,000.00	11,030,000.00	0.00	100.00

(Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,320,000.00	8,320,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,710,000.00	2,710,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00	2,999,600.00	400.00	99.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	2,999,600.00	400.00	99.99
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,000,000.00	2,999,600.00	400.00	99.99
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	427,587,700.00	414,391,107.16	13,196,592.84	96.91
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	427,587,700.00	414,391,107.16	13,196,592.84	96.91
131001	Улсын төсвөөс санхүүжих	427,587,700.00	414,391,107.16	13,196,592.84	96.91